



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/109

Номгон

Төрийн албан хэргийг крилл болон үндэсний  
бичгээр хослон хөтлөх ажлыг эрчимжүүлэх  
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн "Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 07 дугаар тогтоолын 5 дахь заалтыг үндэслэн төрийн албан хэргийг үндэсний бичгээр хөтлөх ажлыг эрчимжүүлэх зорилгоор **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Төрийн албан хэргийг Үндэсний болон кирилл бичгээр хослуулан турших ажлыг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс албан ёсоор мөрдүүлсүгэй.

2.Монгол бичгээр баримт үйлдэх MNS 6395:2022 стандартыг хэрэгжүүлэн, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг), мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг), Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн аймгийн салбар зөвлөл (Б.Нямдолгор), Төрийн архивын тасаг (В.Эрдэнэчимэг)-т тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

02.010179